



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 02.

Улаанбаатар хот

Тэтгэвэр авах дундаж хугацааны
илэрхийллийг тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар өндөр насын тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл ("К")-ийг 2025 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоож мөрдсүгэй.

2. Энэ тогтоолоор баталсан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар өндөр насын тэтгэвэр бодоход баримталж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Ганцэцэг)-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Г.Банзрагч) -нд үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ЭНХ-АМГАЛАН

